



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцоогүй
хөдөө аж ахуйн брокерийн үйл ажиллагаа эрхлэх компаниудын талаар
авах арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 17 хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компаниудыг 2015 оны 6 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцоогүй, зуучлах үйл ажиллагааг эрхлээгүй тохиолдолд тэдгээрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахаар тогтсугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 17 хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компаниудын хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахыг энэхүү тогтоолын 1-д заасан хугацаанд зогсоосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000409

ХААБ-ын нэрс

1. “Батсигнач ХААБ” ХХК
2. “Бурнавасан-Од ХААБ” ХХК
3. “Бурхант таван эрдэнэ” ХААБ ХХК
4. “Говьноос ХААБ ХХК”
5. “Гурван цаст гал тамга” ХААБ ХХК
6. “Түүдкомэкс ХААБ” ХХК
7. “Засагтхан гарьд ХААБ” ХХК
8. “Ийзиплас ХААБ” ХХК
9. “Интерлогик ХААБ” ХХК
10. “Лотускомэкс ХААБ” ХХК
11. “Мөрөнтаван эрдэнэ ХААБ” ХХК
12. “Өлгий түүхий эд ХААБ” ХХК
13. “Өлгий-Ундарга ХААБ” ХХК
14. “Стандарт таваар ХААБ” ХХК
15. “Төвтөвөн эрдэнэ ХААБ” ХХК
16. “ҮСҮ ХААБ” ХХК
17. “Хааннэгдэл ХААБ” ХХК